



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 1/413

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт
төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн салбар”-ын тоног төхөөрөмж-Хөвсгөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай лаборатори болон Оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн (О.Дагиймаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 22-ний өдрийн А/13 дугаар
захирамжийн хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ-ХӨВСГӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД НИЙЛҮҮЛЭХ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Үйл ажиллагаа	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Лабораторийн тоног төхөөрөмж	592,000,000
3	Оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	298,500,000
	Нийт дүн	890,500,000

оОо